## ОТОР НҮҮДЭЛ ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН ХИЙХЭД ХОРИГЛОХ ЗҮЙЛ

- Гэрээт мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид урьдчилан мэдэгдэхгүйгээр бусад сумаас мал, амьтан шилжүүлэн авах;
- Аймаг, сумын Засаг даргын хамтарсан шийдвэрээр отор, эсхүл нүүлгэн шилжүүлэлт хийхээс бусад тохиолдолд Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7.4.1-д заасан ялган тэмдэглэгээ, бүртгэл хийгдээгүй мал, амьтныг сумын нутаг дэвсгэрээс гадагш тээвэрлэх, тууварлах, уналга, эдэлгээнд ашиглах;
- Мал, амьтныг хяналтын цэгт шалгуулахгүй өнгөрөх, эсхүл тогтоосон замаас өөр замаар тээвэрлэх, тууварлах, уналга, эдэлгээнд ашиглах;



- Хорио цээрийн дэглэм тогтоох өвчний жагсаалтад багтсан халдварт өвчин гарсан үед хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоосон бүс хооронд мал, амьтан тууварлах, тээвэрлэх.

Номт 1-р баг
Зуунмод сум
Төв аймаг
Монгол Улс
Цахим хаяг : http://vet.to.gov.mn/
Facebook хаяг: Төв аймгийн Мал

Төв аймгийн Мал эмнэлгийн газар

# Отор нүүдэл шилжилт хөдөлгөөн хийх малчдад өгөх зөвлөмж

ТӨВ АЙМГИЙН МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗАР

ЗӨВЛӨМЖ

МАЛ АМЬТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН АЛБА

УТАС: 70272361

## ОТОР НҮҮДЭЛ ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН ХИЙХЭД МАЛЧИН ТАНЫ ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

- ⇒ Мал, амьтан өмчлөгч мал, амьтнаа ялган тэмдэглэж, бүртгэл хөтлөх;
- ⇒ Нийтийг хамарсан арга хэмжээнд оролцуулах, хээлтүүлэгт ашиглах, худалдах, төхөөрөх зорилгоор мал, амьтныг сумын нутаг дэвсгэрээс гаргахдаа мал эмнэлгийн улсын байцаагчаас мал эмнэлгийн гэрчилгээ авч бүртгүүлэх;
- ⇒ Өөр сумын нутаг дэвсгэрээс мал, амьтан шилжүүлэн авчрах бол мал эмнэлгийн тасагт урьдчилан мэдэгдэж, авчирсан даруй үзлэг хийлгэн тухайн сумын мал эмнэлэг, хөдөө аж ахуйн тасагт бүртгүүлэх.



- ⇒ Мал, амьтан тээвэрлэх, тууварлах талаар эрх бүхий байгууллагаас баталсан журам, зааврыг мөрдөх;
- ⇒ Хүлээн авагч талын Засаг даргаас тогтоож өгсөн нутаг дэвсгэрт оторлох, нүүдэллэх;
- ⇒ Мал, амьтныг тээвэрлэхдээ зориулалтын, эсхүл мал, амьтанд бэртэл гэмтэл учруулахгүй байхаар нэмж тоноглосон тээврийн хэрэгслийг ашиглах, тээвэрлэхийн өмнө механик цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийлгэх;
- ⇒ Отор, нүүдэл болон худалдах, арилжихаас бусад зорилгоор тээвэрлэж, тууварлаж яваа мал, амьтныг тухайн сумын мал эмнэлгийн тасгийн зөвшөөрөлгүйгээр худалдаалах, солих, үлдээхгүй байх;
- ⇒ Мал, амьтны шилжилт хөдөлгөөний үед хорогдсон мал, амьтны хүүр, сэг зэмийг зөвшөөрсөн цэгт заврын дагуу устгах;
- ⇒ Шилжилт хөдөлгөөний үед мал, амьтны өвчний сэжиг илэрсэн тохиолдолд засаг захиргаа, мал эмнэлгийн байгууллагад яаралтай мэдээлэх;
- ⇒ Олон улсын болон улсын чанартай авто зам дамжин өнгөрдөг аймаг, сумын нутаг дэвсгэрээр мал, амьтны шилжилт хөдөлгөөн хийх бол тогтоосон цэгт түр саатах, түр амраах.

Иргэн хуулийн этгээд мал, амьтны шилжилт хөдөлгөөн хийхтэй холбоотой санал, гомдлоо холбогдох эрх бүхий байгууллагад гаргах эрхтэй

**Мал амьтны эрүүл мэндийн алба**

Утас: 7027-2361
Цахим хаяг: http://vet.to.gov.mn/